

# Таваарын зах зээлийн долоо хоногийн тойм

Голомт Капитал ҮЦК ХХК-д бэлтгэв

2022.01.24

Нүүрс  
Төмрийн хүдэр  
Зэс



# НҮҮРСНИЙ ДОЛОО ХОНОГИЙН ТОЙМ

2022 оны 01-р сарын 24

## Долоо хоногийн онцлох үйл явдал

Өнгөрсөн долоо хоногийн даваа гарагт Далианы таваарын биржид арилжаалагдаж буй коксжих нүүрсний фьючерс ханш 2366 юань дээр нээгдсэн бол баасан гарагт 2468 юань хүрч хаагдсанаар 4 хувийн өсөлт үзүүлээ.

China Iron and Steel Association (CISA) байгууллагын мэдээллээр 2022 оны 01 сарын 20 өдрийн байдлаар БНХАУ-ын 21 хотод гангийн голлох бүтээгдэхүүнүүдийн агуулахын нөөц 10 хоногийн өмнөх үеэс 10.2 хувиар өсөж 8.74 сая тоннд хүрсэн байна. Харин тус голлох бүтээгдэхүүнүүдийн арилжааны идэвхи оны эхэн үеэс 10.9 хувиар өндөр өмнөх оны мөн үеэс 0.8 хувиар өндөр байгаа юм байна.

1 сарын 11-20 өдрүүдэд БНХАУ-ын 7 бүс нутагт гангийн бүтээгдэхүүний нөөц нэмэгдсэн байна. Тодруулбал Өмнөд бүсэд 12.2 хувиар буюу 220,000 тонноор, хойд бүсэд 21.1 хувиар буюу 160,000 тонноор, баруун бүсэд 22.4 хувиар буюу 110,000 тонноор, баруун өмнөд бүсэд 7.5 хувиар буюу 100,000 тонноор, зүүн хойд бүсэд 33.3 хувиар буюу 100,000 тонноор, төвийн бүсэд 5.7 хувиар буюу 50,000 тонноор тус тус өссөн байна.

Published on Investing.com, 24/Jan/2022 - 2:36:48 GMT. Powered by TradingView.  
Coking Coal Futures, China, DCE:DJM1, D



Гангийн голлох бүтээгдэхүүнүүдийн нөөцийн өсөлтийг бүтээгдэхүүнүүдээр задлан авч үзвэл арматур 1 сарын 20 өдрийн байдлаар 3.62 сая тоннд хүрч 10 хоногийн өмнөх үеэс 19.1 хувиар өссөн бол арилжааны идэвхи 41.4 хувиар өссөн байна. Харин цувимал ороомгийн нөөц 1.9 хувиар өсжээ. Гангийн нөөц бүс нутгуудаар хангалттай хэмжээнд байгаагаар холбоотой коксжих нүүрсний ханш богино хугацаанд тогтвортой байх төлөвтэй байна.

**Мэдэгдэл:** Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.



# ТӨМРИЙН ХҮДРИЙН ДОЛОО ХОНОГИЙН ТОЙМ

2022 оны 01-р сарын 24

## Долоо хоногийн онцлох үйл явдал

Өнгөрсөн долоо хоногийн даваа гарагт БНХАУ-ын Далианы таваарын биржид арилжаалагдаж буй төмрийн хүдрийн 5 сарын гэрээний ханш 718.5 юань дээр нээгдэж баасан гарагт 752.5 юань дээр хаагдсанаар 4.7 хувийн өсөлт үзүүлээ.

Өнгөрсөн долоо хоногт БНХАУ-ын төв банк бодлогын хүүгийн түвшинг 0.1 хувиар буулгаж 3.7 хувьд хүргэлээ. БНХАУ-ын засгийн газар эдийн засгийн өсөлтийг мөнгөний зөөлөн бодлогоор дамжуулан сэргээх бодлого баримталж буйгаа мэдэгдээд байгаа бөгөөд тус бодлоготой холбоотой 2022 онд эдийн засгийн тэлэлт явагдах төлөвтэй байгааг шинжээчид мэдэгдээд байна.

Бодлогын хүүг бууруулсантай холбоотой Commonwealth Bank of Australia-ийн таваарын шинжээч Vivek Dhar-ын мэдэгдэж байгаагаар төмрийн хүдрийн худалдан авагчдийн эрэлт сэргэх барилгажилт идэвхижих төлөвтэй байгааг мэдэгдсэн байна.

Published on Investing.com, 24/Jan/2022 - 2:55:30 GMT. Powered by TradingView.  
Iron ore fines 62% Fe CFR Futures, China, DCE:DCEIOK2, D



Mysteel-ийн мэдээллээр өнгөрсөн долоо хоногт ган хайлуулах 247 үйлдвэрийн үйлдвэрлэлийн хүчин чадал 79.89 хувиас 81.08 хувь болж өссөн байна. SinoSteel Futures-ийн шинжээчийн мэдэгдэж байгаагаар Өвлийн олимптой холбоотой богино хугацаанд ган үйлдвэрлэлийн түүхий эд материалуудын эрэлт бага байх төлөвтэй байгаа хэдий ч дунд хугацаандаа гангийн бүтээгдэхүүнүүдийн эрэлт эрчимтэй сэргэх төлөвтэй байгааг мэдэгдсэн байна.

**Мэдэгдэл:** Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.



# ЗЭСИЙН ДОЛОО ХОНОГИЙН ТОЙМ

Долоо хоногийн онцлох үйл явдал

2022 оны 1-р сарын 24

Өнгөрсөн долоо хоногийн даваа гарагт Шанхайн таваарын биржид арилжаалагдаж буй зэсийн 11 сарын гэрээний ханш 71,200 юань дээр нээгдэж баасан гарагт 71,150 юань дээр хаагдсанаар томоохон өөрчлөлт үзүүлээгүй байна.

БНХАУ-ын Үндэсний хөгжил шинэчлэлийн хороо болон 6 яамдуудын хамтарсан ногоон эрчим хүчний хэрэглээг дэмжсэн хуулийн төслийг танилцууллаа. Тус хуулийн төслийн гол зорилго нь салбарын тэргүүлэгч томоохон компаниуд, төрийн өмчит компаниуд, олон улс дамжсан корпорациудын ногоон эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэхийг зорьсон байна. Үүнд экспортруу чиглэсэн томоохон компаниуд болон эдийн засгийн хувьд томоохон потенциалтай компаниудын нийт эрчим хүчний хэрэглээнд эзлэх ногоон эрчим хүчний хувийг нэмэгдүүлэх. Өндөр эрчим хүч хэрэглэгдэг компаниудын нийт эрчим хүчний хэрэглээнд эзлэх ногоон эрчим хүчний хувь нэмжээг нэмэгдүүлэх зэрэг шаардлагуудыг тавьж байгаа юм байна.

Published on Investing.com, 24/Jan/2022 - 3:23:54 GMT, Powered by TradingView.  
Copper Futures, China, SHFE:SCF1, D



БНХАУ нь 2060 он гэхэд агаарын бохирдолгүй улс болох төлөвлөгөөтэй байгаа бөгөөд ногоон эрчим хүчний компаниудыг дэмжсэн бодлого баримталж байгаа юм. Эрчим хүчрүү чиглэсэн томоохон төрийн бодлого дэмжлэгүүдтэй холбоотой эрчим хүчний Huaneng Power International, Huadian Power International зэрэг компаниуд өнгөрсөн онд 125.8 болон 70 хувиан өсөлт үзүүлсэн байна.

Дэлхийн томоохон зэс хэрэглэгч орон ногоон эрчим хүчний шилжилт хийх томоохон хуулийн төслүүд баталж байгаа нь зэсийн ханшийг урт хугацаанд өсгөх суурь хүчин зүйл болж байгааг шинжээчид мэдэгдэж байна.

**Мэдэгдэл:** Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.



## Холбоо барих

---



**Т.Азтүшиг**  
Ахлах шинжээч

aztushig@golomtcapital.com  
9997-0303

---

**Golomt Capital®**

---

